

ЭКО-ҮЙЛЧИЛГЭЭ ТББ

Ерөнхий агнуур зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэх, менежментийн төлөвлөгөөг
боловсруулах ажлыг гэрээгээр зохион байгуулсан “Эко-үйлчилгээ” ТББ-ын
танилцуулга

ЭКО-ҮЙЛЧИЛГЭЭ ТББ-ЫН ТАНИЛЦУУЛГА

Биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторийн ажилтнууд болон бусад мэргэжлийн хөхтөн судлаачдын санаачилгаар Эко-үйлчилгээ ТББ –ыг 2013 онд байгуулан Ан амьтны нөөц, тархцыг тогтоох судалгаа, агнуур зохион байгуулалт хийх, зэрлэг хөхтөн амьтныг сэргээн нутагшуулах, үржүүлэх туршилт-судалгааны ажил эрхлэх чиглэлээр Байгаль орчны ан амьтны төрөлд хамаарах мэргэжлийн байгууллагын эрх авсан болно.

Манай байгууллагад харьяалагдаж байгаа хөхтөн судлаачид Монгол орны агнуурын болон экосистемийн өргөн холбогдолтой хөхтөн амьтны тархац, байршил, биологи, экологи, популяцийн бүтэц, үржил, төлжил, тоо толгой, нөөц, экологи-эдийн засгийн үнэлгээ, нөөцийг хамгаалах, зохистой ашиглах үндэслэл, санал, зөвлөмжийг боловсруулах ажилд идэвхитэй оролцон, Монгол Улсын төр засгийн бодлогод тусгуулан хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэсээр ирлээ.

Монгол орны нэн ховор болон экосистемд зонхилох үүрэгтэй хөхтөн амьтдын судалгаанд гадаад болон дотоодын судлаачидтай хамтран оролцож, тэдгээрийн экологи, биологи, хамгааллын менежменттэй холбоотой сэдвээр гадаад дотоодын эрдэм шинжилгээний бүтээлүүдэд 419 гаруй өгүүлэл, нэг сэдэвт ном зохиол, орчуулгын бүтээл 29-ийг хэвлүүлснээс гадна Монгол, АНУ, Австри, Хятад зэрэг орнуудад эрдэм шинжилгээний их, бага хурлуудад 293 удаа илтгэл тавьсан байна.

БОНХЯ, НҮБХХ, Байгаль орчны шинэчлэл II төслийн захиалгаар 2001, 2003, 2004, 2007, 2010, 2011, 2012 онд үндэсний хэмжээнд хийж гүйцэтгэсэн Монгол орны уулын туруутан, тал хээрийн туруутан, ойн туруутан болон мазаалай баавгай, хавтгай тэмээний популяцийн нөөц, тархац нутгийн үнэлгээний ажилд оролцон дээрх хөхтөн амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх шинжлэх ухааны санал зөвлөмжийг боловсруулан гаргах ажилд оролцон, бүс нутагт хээрийн хайгуул судалгааны ажлыг зохион байгуулах, тайланг нэгтгэн тухайн үеийн БОАЖЯ-нд хүлээлгэж өгсөн.

ГТХАН, “Дорнод Монголын биологийн төрөл зүйл төсөл”, WWF, “Австралийн байгаль хамгаалах сан” зэрэг байгууллагуудын захиалгаар Хан Хэнтий, Лхачинвандад уул, Сийлхэмийн нуруу, Өшгийн нуруу, Түргэн-Цагаан шувуут зэрэг улсын болон орон нутгийн хамгаалалттай газар нутагт тархсан хөхтөн амьтдын тоо толгой, тархац байршил,

нөөцийн судалгааг хийж тэдгээрийг хамгаалах, зүй зохистой менежментийг төлөвлөхөд тус төрийн бус байгууллагын нэр бүхий гишүүд оролцон, тайланг холбогдох газруудад хүлээлгэн өгсөн.

Аймгийн ЗДТГ-ын болон бүс нутгийн агнуурын менежментийг хариуцаж буй төрийн бус байгууллагуудын захиалгаар *Хэнтий, Архангай, Төв, Ховд, Сүхбаатар, Увс* аймгийн нутагт тархсан агнуурын хөхтөн амьтны тооллого судалгааны үндсэн дээр агнуур зохион байгуулалтын үндэслэл болон менежментийн төлөвлөгөө боловсруулах ажилд оролцсон.

Тус төрийн бус байгууллагын нэр бүхий гишүүд Монгол оронд байгаль орчинд ээлтэй уул уурхайг хөгжүүлэх, уул уурхайгаас бүс нутгийн хөхтөн амьтад, экосистемд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тогтоох, тэдгээрийг бууруулах санал зөвлөмж боловсруулах ажлын багт цөөнгүй удаа оролцон хээрийн судалгааг гүйцэтгэж, тайлан, үр дүнг нэгтгэн гаргажээ. Түүнчлэн Монгол орны экосистемийн олон талт судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэж, хээрийн судалгааны эх мэдээ хэрэглэхүүнд орчин үеийн программ хангамж, тоног төхөөрөмж хэрэглэн боловсруулж эрдмийн зэрэг цол хамгаалсан бөгөөд эдгээр ажлуудаас дурдвал Их нарт орчмын дагуур болон дэлдэн зарааны биологи, экологийн судалгаа, Ар Өнжүүлийн уулсын мануул мийн биологи, экологийн судалгаа зэрэг болно.

Тус төрийн бус байгууллагын гишүүд Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар (WWF Mongolia), Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS), Де Нэйчэ Консерванси (TNC), НҮБХХ, Байгаль орчны шинэчлэл-II зэрэг гадаад, дотоодын байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөртэй нягт хамтран ажиллаж, Монгол орны ховор болон экосистемд чухал үүрэгтэй хөхтөн амьтдын популяцийн үнэлгээг хийж гүйцэтгэн, тэдгээрийн хамгаалах зөвлөмж боловсруулсан байна.

ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран ТХГН-т хөхтөн амьтдын амьтдын популяцийн тоо толгойг үнэлэх, хянах, мониторинг хийх хялбаршуулсан арга зүйг боловсруулж, байгаль хамгаалагч орон нутгийн идэвхтэн гишүүдийг уг арга зүйд сургаж дадлагажуулах тал дээр БОНХЯ-ны ТХГНБТөсөлтэй хамтран ажиллаж байсан бөгөөд уг арга зүйн дагуу цуглуулсан мэдээллийг нэгтгэн боловсруулж үр дүнг захиалагч байгууллагад хүргүүлэх ажилд оролцож байв. Мөн Монгол улсын Улаан номны хоёр болон гуравдахь хэвлэлийн Амьтан судлалын хэсгийг боловсруулах багийн бүрэлдэхүүнд оролцсон байна.

Хээрийн судалгаанд болон лабораторийн боловсруулалтанд судалгааны орчин үеийн багаж хэрэгсэл, арга зүйг өргөн хэрэглэж олон улсын нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлүүдэд 50 гаруй өгүүлэл хэвлүүлснээс гадна лабораторийн эрдэмтдийн бүтээлүүдийг гадаадын эрдэмтэд иш татан хэрэглэж байгаа нь манай хөхтөн судлаачид олон улсын түвшинд өндөр үнэлэгддэг болсныг гэрчилнэ.

Одоо тус байгууллагын боловсон хүчнийг ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лаборатори, Шувуу судлалын лаборатори, Монгол улсын их сургуулийн Байгалийн ухааны салбар сургуулийн Биологийн тэнхимийн төдийгүй Английн Нотэнхимийн их сургуулийн докторант оюутан зэрэг тал талын төлөөлөл оролцсон нийт 10 судлаач бүрдүүлж байна. Манай байгууллагад Биологийн ухааны доктор 4, докторант 4, магистр -1 байгаагаас агнуур зүйн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан 2 доктор, 1 магистр тус тус гишүүнчлэлтэй байна.

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2013.11.20

№ 000067770

9071041046

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

/ Улсын бүртгэлийн дугаар /

8120358

/ Регистрийн дугаар /

Эко-Үйлчилгээ

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

01

2013.11.19

/ шийдвэрийн нэр /

/ дугаар /

/ он, сар, өдөр /

9499

/ код /

Биологийн судалгаа шинжилгээ хийх, сургалт, семинар зохион байгуулах, аялал
жуулчлалын салбарын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

1

20.00

/ хугацаа /

/ гишүүдийн тоо /

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 7-р хороо, 11 хороолол, 7, 195 тоот, Утас1: 98128048, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэлийн ерөнхий
газрын Бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /



